


ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/022/НА-СТА-ТШЗ

|                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
|-----------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас:<br><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Алтай хот<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a><br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a><br>Цэгц богд төв аудит ХХК-ийн Ахлах аудитор:<br>Р.Цанжидмаа<br>Утас: 99029885 Цахим хаяг: <a href="mailto:tsania.0215@gmail.com">tsania.0215@gmail.com</a> |
|-----------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.  
ГАА-2025/022/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хөрөөлөл, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ДЭЛГЭР  
СУМЫН ГУУЛИН ТОСГОНЫ ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Д.ЦЭЭНОРОВ ТАНАА

2025. 02.21 № 22

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэр сумын Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөн-ө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5, 25 дугаар зүйлийн 25.8 дахь, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дахь, 73 дугаар зүйлийн 73.2 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Эм боох материалын зардлын төсвөөс 2,090.0 мянган төгрөгийн хүнс, бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний зардлыг зарцуулсан, цалингийн зардлын төсвөөс 6,720.3 мянган төгрөгийн эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн ,
- Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 27,064.3 мянган төгрөг хасагдсан,

8225020059

- Хандив тусламж үнэ төлбөргүй , шилжүүлэн орлого авсан 230,455.8 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан акт үйлдээгүй,
- Хөрөнгийн тооллогын бүртгэлээрх 686,535.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг тооцоо бодож баталгаажуулаагүй.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Эрүүл мэндийн төв 2024 онд давхардсан тоогоор 2485 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн Б/03 дугаар тушаалаар “Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн орон тооны хязгаар”-ыг 22 орон тоогоор баталж, гүйцэтгэлээр 14 орон тоотой ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилт өмнөх оноос 132,417.8 мянган төгрөгөөр өсжээ. Энэ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тоо өссөн, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 05 дугаар тогтоолоор эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээ, өрх сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж үйлчилгээний тохиолдолд суурилсан төлбөрийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөр 141,482.0 мянган төгрөгийг нэхэмжилснээс 117,766.9 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас авч 23,715.1 мянган төгрөг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтаар хасагдаж орлого төвлөрүүлэх боломж алдсан байна.

#### **Бусад асуудал**

Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 3 зорилт 16 арга хэмжээний хэрэгжилт 96.8 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

|                                                | Үзүүлэлт                                          | 2023.12.31       | 2024.12.31       |
|------------------------------------------------|---------------------------------------------------|------------------|------------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                  |                  |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 83,527.3         | 164,788.2        |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 318,234.0        | 508,762.9        |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>401,761.3</b> | <b>673,551.1</b> |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             | -                | 3,307.6          |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 401,761.3        | 670,243.5        |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>401,761.3</b> | <b>673,551.1</b> |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |                                                   |                  |                  |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 425,492.4        | 736,466.6        |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 361,555.0        | 467,984.4        |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>63,937.4</b>  | <b>268,482.2</b> |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        | -                | -                |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>63,937.4</b>  | <b>268,482.2</b> |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                  |                  |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 337,823.9        | 401,761.3        |
|                                                | Тайлант оны үр дүн                                | 63,937.4         | 268,482.2        |
|                                                | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт        |                  |                  |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>401,761.3</b> | <b>670,243.5</b> |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                  |                  |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 366,473.9        | 442,361.2        |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 326,979.0        | 422,799.6        |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>39,494.9</b>  | <b>19,561.6</b>  |
|                                                | Хөрөнгө оруулалтын ЦМГ                            | -                | (12,744.6)       |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 | <b>-</b>         | <b>-</b>         |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>39,494.9</b>  | <b>6,817.0</b>   |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 41.9             | 39,536.9         |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 39,536.9         | 46,353.9         |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>             |                                                   |                  |                  |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | <b>554,514.7</b> | <b>435,104.2</b> |
|                                                | Урсгал зардал                                     | 554,514.7        | 435,104.2        |
|                                                | Хөрөнгийн зардал                                  |                  |                  |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             | <b>554,514.7</b> | <b>441,921.2</b> |
|                                                | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих         | 489,177.8        | 415,931.3        |
|                                                | Орон нутгийн төсвөөс санхүүжих                    | <b>18,300.0</b>  | <b>17,860.0</b>  |
|                                                | Туслах үйл ажиллагааны орлого                     | 7,500.0          | 8,129.9          |
|                                                | Урьд оны үлдэгдлээс санхүүжих                     | 39,536.9         |                  |

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Залруулагдаагүй материаллаг 8,810.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түшингээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар материаллаг 8,810.3 мянган төгрөгийн 1 зөрчил, материаллаг бус 3 зөрчил илэрч 2 зөвлөмж, 2 зөрчил арилгах, давтан гаргахгүй албан шаардлага өгсөн.

### Албан шаардлага

1. Хөрөнгийн тооллогын бүртгэлээрх 686,535.7 мянган төгрөгийн хөрөнгийн тооцоог бодож баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дахь Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна., 12.2 дахь Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ, 12.2.1 дахь жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6 дахь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дахь комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх, 73 дугаар зүйлийн 73.2 дахь Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана заалттай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хийж үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлтэй тулган баталгаажуулж тооцоо бодоогүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Эм боох материалын зардлаас 2,090.0 мянган төгрөгийн хүнсний материал, бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний зардал төлсөн, цалингийн зардлаас 6,720.3 мянган төгрөгийн эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавартай тус тус нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, эм боох материалын зардлаас хүнсний материал худалдан авч буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

### Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 27,064.3 мянган төгрөг хасагдсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг нэхэмжлэхдээ даатгуулагчийн төлбөрийн тооцоо, холбогдох мэдээллийг үнэн, зөв, цаг хугацаанд нь цахим системд бүртгэж, үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлэн, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аудитаар Хандив тусламж үнэ төлбөргүй ирсэн 230,455.8 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан акт баримт үйлдэгдээгүй, нягтлан бодох бүртгэлд тусгасан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/203 дугаар тушаалын хавсралт Тусламж хандиваар эм , эмнэлгийн хэрэгсэл хүлээн авах, хэрэглэх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хандив тусламж, үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах комисс хүлээн авч байгууллагын даргын тушаалаар нягтлан бодох бүртгэлд авч, албан хаагчдад эд хөрөнгийн картаар эзэмшүүлэн, хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Байгууллагын нэр                | Нийт алдаа |     | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |     | (мянган төгрөгөөр) |   |               |   | Зөвлөмж |     |
|---------------------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|--------------------|---|---------------|---|---------|-----|
|                                 |            |     |                                   |     |                          |     | Үүнээс             |   |               |   |         |     |
|                                 | Тоо        | Дүн | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн | Залруулсан         |   | Залруул аагүй |   | Тоо     | Дүн |
| Дэлгэр сумын Гуулин тосгоны ЭМТ | -          | -   | -                                 | -   | -                        | -   | -                  | - | -             | - | -       | -   |
| Дүн                             | -          | -   | -                                 | -   | -                        | -   | -                  | - | -             | - | -       | -   |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | (мянган төгрөгөөр) |                 |         |                                      |                              |
|------------------|-------------|--------------------|-----------------|---------|--------------------------------------|------------------------------|
|                  |             | Төлбөрийн акт      | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад |
|                  |             |                    |                 |         |                                      |                              |

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|                                 |     |         |     |     |     |         |     |     |     |                     | шилжүүлсэн асуудал |     |
|---------------------------------|-----|---------|-----|-----|-----|---------|-----|-----|-----|---------------------|--------------------|-----|
|                                 | Тоо | Дүн     | Тоо | Дүн | Тоо | Дүн     | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо                | Дүн |
| Дэлгэр сумын Гуулин тосгоны ЭМТ | 4   | 8,810.3 | -   | -   | 2   | 8,810.3 | 2   | -   | -   | -                   | -                  | -   |
| Дүн                             | 4   | 8,810.3 | -   | -   | 2   | 8,810.3 | 2   | -   | -   | -                   | -                  | -   |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

( мянган төгрөгөөр)

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр                      | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |
|----------------------------------------------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|                                                          |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|                                                          | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |     |               |     |                 |     |         |     |
| Дэлгэр сумын Гуулин тосгоны ЭМТ                          | 1           | -   | -             | -   | -               | -   | 1       | -   |
| Дүн                                                      | 1           | -   | -             | -   | -               | -   | 1       | -   |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |     |               |     |                 |     |         |     |
|                                                          | -           | -   | -             | -   | -               | -   | -       | -   |
| Дүн                                                      | -           | -   | -             | -   | -               | -   | -       | -   |
| -Нийт дүн                                                | -           | -   | -             | -   | -               | -   | -       | -   |

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Өөрчлөлтгүй             | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         |                          | 1                           |                    |                 |                         | 1              |       |                            |
|   | НИЙТ                        |                          | 1                           |                    |                 |                         | 1              |       |                            |